

Golomt Capital®

# БОНДЫН

---

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ



2025.10.29



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.51%
Монгол 27	2027.07.07	3.50%	5.62%
Хүннү	2028.01.19	8.65%	5.71%
Монгол 29	2029.06.05	7.875%	5.97%
Монгол 30	2030.02.25	6.625%	6.03%
Монгол 31	2031.07.07	4.45%	6.28%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 5.51%-6.28% хооронд хэлбэлзэж байна.



## КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.84%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	12.02%
TDBM	2027.12.23	8.5%	8.96%
DBM	2026.03.07	11.00%	5.00%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 5.00%-12.02%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. АНУ-ын бодлогын хүү буурах магадлал нэмэгдсэнтэй холбоотой бондуудын эрэлт нэмэгдэж үнэ түүнийгээ дагаад нэмэгдсэн байна. Иймээс ам.долларын бондуудын өгөөж буурсан дүр зурагтай байна.

Хэрэв энэ ондоо багтан АНУ-ын бодлогын хүүг нийтдээ **50 суурь** нэгжээр буюу 0.5 хувиар бууруулбал АНУ-ын засгийн бондуудын өгөөж дунджар **0.7 хувиар** буурах магадлалтай юм. Ингэснээр бондуудын үнэ нэмэгдэх учир яг одоо засгийн долларын бондуудад хөрөнгө оруулбал тохиромжтой үе ирээд байна.

## AM.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

### Төгрөгийн бонд эсвэл ам.долларын бонд

	Төгрөгийн бонд	Ам.долларын бонд
Хүү /хагас жил тутам/	19%	11%
1 жилийн дараах өгөөж <i>*Валютын ханшийн зөрүүг тооцоогүй</i>	19.9%	11.3%
2 жилийн дараах өгөөж <i>*Валютын ханшийн зөрүүг тооцоогүй</i>	43.77%	23.88%

USD/MNT 3700 1 жилийн дараа	14.65%
USD/MNT 3750 1 жилийн дараа	16.20%
USD/MNT 3800 2 жилийн дараа	31.06%

1 жилийн дараа төгрөгийн ам.доллартай харьцах ханш **3869₮** хүрч байж өгөөж тэнцэнэ.

Мөн хэрэв 2 жилийн дараа төгрөгийн ам.доллартай харьцах ханш **4168₮** хүрч байж өгөөж тэнцэнэ.

График 2. Ам.долларын индекс



TradingView

### Холбооны Нөөцийн Банкны ээлжит хурал

Зах зээл 100%-ийн магадлалтайгаар ХНС 0.25 хувиар дахин хүүгээ бууруулна гэж үзэж байна. Энэ нь дараалан хоёр дахь хүү бууралт бөгөөд бодлогын хүү 4.0–4.25% → 3.75–4.0% түвшинд хүрэх төлөвтэй.

Эдийн засгийн үзүүлэлтүүд буюу инфляцийн тайлан болон хөдөлмөрийн зах зээлийн мэдээ чухал нөлөөг үзүүлж байгаа юм. Мэдээж хөдөлмөрийн зах зээлийн сулралыг бууруулж ажил эрхлэлтийн байдлыг дэмжихийн тулд мөнгөний зөөлөн бодлогын хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.



## ДОТООДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## Анхдагч зах зээлээс авах боломжтой бондууд


№	Бондын нэр	Төрөл	Купон	Хүү төлөлт	Салбар	Хугацаа	Захиалга эхлэх хугацаа
1	БСБ Финанс Бонд	Хаалттай	19.00%	Улирал тутам	ББСБ	12 сар	10 сараас
2	Хан-алтай Бонд	Хаалттай	20.00%	Улирал тутам	Уул уурхай	24 сар	10 сараас
3	Бэрс Бонд	Нээлттэй	19.50%	Улирал тутам	ББСБ	24 сар	9 сарын сүүлээр

## Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



**ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА  
3 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ  
БОНД ЗАХИАЛГА  
АВЧ БАЙНА**

8083-7744 | 8665-4422 | 8665-1177